ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn

2022.05.03 № 1/352

танай ____________ -ны № ________________-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлуулах" (Түнэл сум) зөвлөх үйлчилгээ ХӨАОНӨГ/202212063 дугаартай төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад "Ланрес" ХХК, "Гурван тайга" ХХК, "Говь-Эко" ХХК, "Лапланд эко" ХХК, "Цолмон-Арт" ХХК-ууд тендер ирүүлсэн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлуулах" (Түнэл сум) зөвлөх үйлчилгээ ХӨАОНӨГ/202212063 дугаартай тендерт "Лапланд эко" ХХК нь 38,850,790 (Гучин найман сая найман зуун тавин мянга долоон зуун ерэн мянган) төгрөгийн үнийн саналтай тендер ирүүлсэн байна. Уг тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.7.4, 36 дугаар зүйлийн 36.16 дахь заалтуудыг хангаж байгаа тул "Лапланд эко" ХХК-ийг гүйцэтгэгчээр шалгаруулж, дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлуулах" (Түнэл сум) зөвлөх үйлчилгээ ХӨАОНӨГ/202212063 дугаартай тендерт "Ланрес" ХХК нь 46,145,000 (Дөчин зургаан сая нэг зуун дөчин таван мянган), "Говь-Эко" ХХК нь 38,900,000 (Гучин найман сая есөн зуун мянган) төгрөгийн үнийн саналтай тендерүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дахь заалтыг хангаагүй байгаа тул хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтаар уг шалгараагүй тул шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлуулах" (Түнэл сум) зөвлөх үйлчилгээ ХӨАОНӨГ/202212063 дугаартай тендерт "Гурван тайга" ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзэхэд 1,385,188 (Нэг сая гурван зуун наян таван мянга нэг зуун наян найман мянган) төгрөгийн татварын өртэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтыг хангаагүй байгаа тул хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтаар уг тендерээс татгалзаж байгаа тул татгалзсан тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлуулах" (Түнэл сум) зөвлөх үйлчилгээ



6712020210

ХӨАОНӨГ/202212063 дугаартай тендерт "Цолмон-Арт" ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзэхэд тендерийн баримт бичгийн ТӨЗ-д заасан "Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх" Мэргэжлийн байгууллагын зөвшөөрлийн шаардлагыг хангахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтыг хангаагүй байгаа тул хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтаар уг тендерээс татгалзаж байгаа тул татгалзсан тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Үнэлгээний хорооны шийдвэр, дүгнэлтийг хавсаргав

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

6716129061 4131053

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn
2022.05.05 № 1/357
танай ______ -ны № ______-т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Г.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Танай байгууллагын хүсэлтийн дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт Урсгал засварын материал нийлүүлэх ХӨАНЭ/202201024 дугаартай төсөл арга хэмжээг хуулийн дагуу харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар 3 удаа төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгууллаа.

Уг тендер шалгаруулалтад одоогоор нэг ч оролцогч ороогүй байна.

Манай байгуулага нь тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах боломжгүй тул Нэгдсэн эмнэлэг нь өөрийн байгуулага дээрээ тендер шалгаруулалтыг хуульд нийцүүлэн зохион байгуулана уу.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

6718*29351 4131053

d/A4
6712020214

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn
2022.05.09 № 1/359
танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж (Хөвсгөл) төсөл арга хэмжээг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох XVII.3.12 ХХААХҮЯ/202212034 дугаартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтын Багц-1 Хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмж нийлүүлэх багцад "Сосо-Инк" ХХК 99,900,000 төгрөгийн үнийн саналтай тендерийг ирүүлсэн байна. Багц-2 Газар тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмж иж бүрдэл нийлүүлэх багцад оролцогч ороогүй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж (Хөвсгөл) төсөл арга хэмжээг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох XVII.3.12 ХХААХҮЯ/202212034 дугаартай төсөл, арга хэмжээний Багц-1 Хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгч сонгох тендерт оролцсон "Сосо-Инк" ХХК-ийн ирүүлсэн тендерийн баримт бичиг нь ТШЗ 18.6 *Ижил төстэй гэрээний Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ* гэсэн боловч ирүүлээгүй, ТШЗ 18.6.3 *Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: "Шаардана"* гэсэн боловч ирүүлээгүй нь тус тус Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дэх заалтыг хангахгүй байгаа тул татгалзсан үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байна.

Иймд Багц-2 Газар тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмж иж бүрдэл нийлүүлэх багцад оролцогч ороогүй болон Багц-1 Хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмж нийлүүлэх шаардлага хангахгүй байгаа тул дахин зарлах.

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

6716*29361 4131053

d/A4
6712020219

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn

2022.05.09 № 1/360

танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Г.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Танай байгууллагын хүсэлтийн дагуу аймгийн Аймгийн нэгдсэн эмнэлгийн багаж техник хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАНЭ/202201009 дугаартай худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад доор дурдсан танилцуулга зөвлөмжийг хүргүүллээ. Уг тендерийг төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зарлаж, гүйцэтгэгчийг сонгосон болно.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн багаж техник хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАНЭ/202201009 дугаартай тендер шалгаруулалтад "Сүвэн-Уул" ХХК 153,643,400 төгрөгийн үнийн саналтай тендерийг тус тус ирүүлсэн байна.

Нэгдсэн эмнэлэгт багаж техник хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАНЭ/202201009 дугаартай тендер шалгаруулалтын "Сүвэн-Уул" ХХК-ийн 153,643,400 (Нэг зуун тавин гурван сая зургаан зуун дөчин гурван мянга дөрвөн зуун) төгрөгийн үнийн саналтай тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангасан тул гүйцэтгэгчээр шалгаруулав.

Иймд "Сүвэн-Уул" ХХК -тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна.

Захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа дараах зүйлийг анхаарна уу.

Шалгарсан болон шалгараагүй оролцогчдод хуулийн хугацаанд нэгэн зэрэг мэдэгдэл хүргүүлэх,

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу www.shilendans.gov.mn сайт болон орон нутгийн цахим сайтад тендер шалгаруулалтын ерөнхий мэдээллийг тендер нээсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор байршуулах,

Тус газраас хүргэсэн дараах маягтууд, тендерийн баримт бичиг болон бусад материалыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.2-т заасны дагуу архивын нэгж болгон хадгалах. Үүнд:

-Захиалагчаас боловсруулсан тендерийн баримт бичиг
-Тендерийн нээлтийн тэмдэглэл
-Үнэлгээний хорооны гишүүдээс авсан "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"
-Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтүүд
-Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг
-Төрийн худалдан авах ажиллагааны цахим сайтаас хэвлэсэн тендер шалгаруулалтын үр дүнгийн мэдээлэл
-Шалгарсан болон шалгараагүй оролцогчид хүргэх мэдэгдэл (төсөл хэлбэрээр)

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

6716129361 4131053

d/A4

6712020229

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn
2022.05.29 № 1/361
танай ________ -ны № ________-т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Г.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Танай байгууллагын хүсэлтийн дагуу Аймгийн нэгдсэн эмнэлэгийн эм, эмийн хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАНЭ/202201010 дугаартай төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дахин зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурьдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Санхүүжилтийн эх үүсвэр – улсын төсвийн урсгал зардал
   Нийт батлагдсан төсөвт өртөг 2,302,139,988 төгрөг
   Багц-3 Сэтгэц нөлөөт уналт салга өвчины эмнүүд – 5,583,440 төгрөг
   Багц-20 Халдваргүйтгэл ариутгалын бодисууд /гадаад/ - 33,129,560 төгрөг
   Багц-21 Бусад эмийн бэлдмэлүүд – 32,283,260 төгрөг
   Багц-28 Бактериологийн урвалжууд /Хагас автомат/ - 44,723,300 төгрөг
   Багц-29 Эмнэлэгийн зориулалттай хий – 1,320,000 төгрөг
   Багц-32 Өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгсэл – 125,295,500 төгрөг
2. Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтын үлдэгдэл 6 багц тус бүрт дор дурьдсан оролцогчид шалгарсан болон шалгараагүй үндэслэл, үнийн санал бүхий тендерүүдийг тус тус ирүүлсэн байна. Шаардлагад нийцсэн тендерийг багц бүрт харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо авсан дүнгээр үнэллээ.

**Багц-3 Сэтгэц нөлөөт уналт таталт салга өвчний эмүүд багцад:**

а) Монгол эм импекс концерн ХХК – 7,928,617 шалгараагүй. Захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5% хэтэрсэн үнийн санал ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтын дагуу татгалзсан.

**Багц-20 Халдваргүйтгэл ариутгалын бодисууд /гадаад/ багцад:**

а) Нэг ч оролцогч оролцоогүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дахь заалтын дагуу бүх тендерээс татгалзсан.

**Багц-21 Бусад эмийн бэлдмэлүүд багцад:**

а) Нэг ч оролцогч оролцоогүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дахь заалтын дагуу бүх тендерээс татгалзсан.

**Багц-28 Бактерлогийн урвалжууд /хагас автомат/ багцад:**

а) Нэг ч оролцогч оролцоогүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дахь заалтын дагуу бүх тендерээс татгалзсан

**Багц-29 Эмнэлгийн зориулалттай хий багцад:**

а) Нэг ч оролцогч оролцоогүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дахь заалтын дагуу бүх тендерээс татгалзсан.

**Багц-32 Өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгсэл багцад:**

а) Нэг ч оролцогч оролцоогүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дахь заалтын дагуу бүх тендерээс татгалзсан.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын дагуу гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж болох бөгөөд уг гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ мөн хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан этгээдийн сонгож хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа дараах зүйлийг анхаарна уу.

1. Шалгарсан болон шалгараагүй оролцогчдод хуулийн хугацаанд нэгэн зэрэг мэдэгдэл хүргүүлэх,
2. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах,
3. Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон барааны нэгжийн үнэ өөрчлөгдөхгүй байхаар бараа нийлүүлэлтийн хуваарьт тусгаж, нийт үнээр гэрээ байгуулна.
4. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу www.shilendans.gov.mn сайт болон орон нутгийн цахим сайтад тендер шалгаруулалтын ерөнхий мэдээллийг тендер нээсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор байршуулах,
5. Гэрээ байгуулахад оролцсон төрийн албан хаагчдаас “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бөглөж Авлигатай тэмцэх газрын сайтад шивж оруулах,
6. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэх,
7. Санхүүжилтийн хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, бараа бүрийн техникийн тодорхойлолтыг захиалагч, гүйцэтгэгчээр баталгаажуулж гэрээнд хавсаргах,
8. Тус газраас хүргэсэн дараах маягтууд, тендерийн баримт бичиг болон бусад материалыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.2-т заасны дагуу архивын нэгж болгон хадгалах. Үүнд:
   - Захиалагчаас боловсруулсан тендерийн баримт бичиг
   - Тендерийн нээлтийн тэмдэглэл
   - Үнэлгээний хорооны гишүүдээс авсан ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
   - Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтүүд
   - Үнэлгээний хүснэгтээр гаргасан тендерийн үнэлгээ
   - Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг
   - Төрийн худалдан авах ажиллагааны цахим сайтаас хэвлэсэн тендер шалгаруулалтын үр дүнгийн мэдээлэл
   - Үнэлгээний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө
   - Шалгарсан болон шалгараагүй оролцогчид хүргэх мэдэгдэл
9. Тендер шалгаруулалт гэрээлэх ажиллагааны үр дүнг www.umch.khs.gov.mn болон байгууллагынхаа сайтад гэрээ байгуулсан өдрөөс хойш 7 хоногийн дотор нийтлэх.
10. Гэрээний эх хувь болон мэдэгдлийн хуулбар хувийг гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор манай газарт ирүүлэх.

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд: Гэрээний нэр, үнэ, өртөг, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд оруулсны дараа гүйцэтгэгчид санхүүжилт олгох тухай заавж өгөх.

Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тухай үнэлгээний хорооны шийдвэр, мэдэгдлийн төслийг хавсаргав.

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn

2022.05.04 № 1/362

танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр батлагдсан Сумын төвийг шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажил /Ханх сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг/-ын гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212037 дугаартай төсөл арга хэмжээний хэмжээний худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад “Пи Эс Пи” ХХК 193,556,140 (Нэг зуун ерэн гурван сая таван зуун тавин зургаан мянга нэг зуун дөчин) төгрөг, “ЖЕММН” ХХК 188,011,111 (Нэг зуун наян найман сая арван нэгэн мянга нэг зуун арван нэгэн) үнийн саналтай тендерүүдийг ирүүлсэн байна.

Сумын төвийг шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажил /Ханх сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг/-ын гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад “Пи Эс Пи” ХХК –ийн ирүүлсэн тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дахь заалтыг хангаагүй байгаа тул хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтаар шалгараагүй тул шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Сумын төвийг шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажил /Ханх сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг/ - ын гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад “ЖЕММН” ХХК-ийн ирүүлсэн тендер нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулах үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байна.

Иймд “ЖЕММН” ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалтыг үндэслэн гэрээ байгуулахыг зөвлөж байна.

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал эцсийн санхүүжилтээс аймгийн Төрийн сангийн 100-170051305 тоот дансанд авч байршуулах, эсвэл Засгийн газрын бондоор баталгааг гаргуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд барьцаалсан мөнгөн хөрөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгож болно.

Үнэлгээний хорооны дүгнэлт шийдвэрийг хавсаргав.

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

6716129361 4131053

d/A4

6712020223

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn
2022.05.09 № 1/363

танай ____________ -ны № ________________-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засварын ажлын гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212083 дугаартай төсөл арга хэмжээний хэмжээний худалдан авах ажиллагаар www.tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад “Ихрийн бууц” ХХК 239,346,128 (Хоёр зуун гучин есөн сая гурван зуун дөчин зургаан мянга нэг зуун хорин найман) төгрөг, “Бунбах” ХХК 238,905,984 (Хоёр зуун гучин найман сая есөн зуун таван мянга есөн зуун наян дөрвөн) төгрөг, “Зэвт номгон” ХХК 243,744,946 (Хоёр зуун дөчин гурван сая долоон зуун дөчин дөрвөн мянга есөн зуун дөчин зургаан) төгрөгийн үнийн саналтай тендерүүдийг ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засварын ажлын гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад “Бунбах” ХХК-ийн ирүүлсэн тендер нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулах үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байна.

Иймд “Бунбах” ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалтыг үндэслэн гэрээ байгуулахыг зөвлөж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засварын ажлын гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад “Ихрийн бууц” ХХК –ийн ирүүлсэн тендер нь шалгарсан оролцогчийн үнийн саналаас 440,144 (Дөрвөн зуун дөчин мянга нэг зуун дөчин дөрвөн) төгрөгөөр илүү байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дахь заалтыг хангаагүй байгаа тул хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтаар шалгараагүй тул шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын их засварын ажлын гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад “Зэвт номгон” ХХК –ийн ирүүлсэн тендер нь шалгарсан оролцогчийн үнийн саналаас 4,838,962 (Дөрвөн сая найман зуун гучин найман мянга есөн зуун жаран хоёр) төгрөгөөр илүү байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дахь заалтыг хангаагүй байгаа тул хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтаар шалгараагүй тул шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал эцсийн санхүүжилтээс аймгийн Төрийн сангийн 100-

170051305 тоот дансанд авч байршуулах, эсвэл Засгийн газрын бондоор баталгааг гаргуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд барьцаалсан мөнгөн хөрөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгож болно.

Үнэлгээний хорооны дүгнэлт шийдвэрийг хавсаргав

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

6716129361 4131053

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn
2022.05.09 № 1/364
танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Г.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн нэгдсэн эмнэлэгт хоолны материал худалдан авах гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтыг 2 дахь удаагаа зохион байгуулсан үнэлгээний хорооны хорооны шийдвэрийг хянаад дор дурдсан зөвлөмжийг хүргүүллээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт хоолны материал худалдан авах гүйцэтгэгч сонгох тендерийг 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдөр зарлан 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр нээхэд гурил будаа хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 2 дугаар багцад оролцогчгүй, Цагаан идээ хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 3 дугаар багцад "Мөрөн буян ундрах" ХХК 27,400,000.0 төгрөгийн үнийн санал ирүүлсэн, Будаа хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 4 дүгээр багц, ногоо хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 5 дугаар багцуудад тус тус нэг ч аж ахуйн нэгж оролцоогүй байна.

"Мөрөн буян ундрах" ХХК 27,400,000.0 төгрөгийн үнийн саналтай тендер нь захиалагчийн тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцсэн тул ТБОНӨХБАҮХАТХуулийн хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангасан хэмээн үнэлсэн үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байх тул Нэгдсэн эмнэлэгт хоолны материал худалдан авах тендерийн Цагаан идээ хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 3 дугаар багцад 27,400,000.0 төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Мөрөн буян ундрах" ХХК -ийг шалгаруулж, түүнд гэрээ байгуулах эрх олгохыг зөвлөж байна.

Гурил будаа, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 2 дугаар, будаа, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 4 дүгээр, ногоо хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 5 дугаар багцуудын тендерийг тус бүр 2 удаа зарлахад тендер шалгаруулалт 2 удаа амжилтгүй болж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨХБАҮХАТХууль)-ийн 30 дугаар зүйлийн 30.4.1, 30.4.3 дахь хэсгүүдэд заасан нөхцөл үүссэн тул ТБОНӨХБАҮХАТХуулийн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг үндэслэн мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт заасны дагуу Нэгдсэн эмнэлэгт хүнсний материал нийлүүлэх тендерийн 3, 4, 5 дугаар багцуудад заасан барааг гэрээ шууд байгуулах аргаар худалдан авахыг зөвлөж байна.

Уг зөвлөмжид дараах баримт бичгийг хавсарган хүргүүлэв. Үүнд:

1. Захиалагчийн тендерийн баримт бичиг, үнэлгээний хороо байгуулсан тухай газрын даргын 2022 оны А/04, А/23 дугаар тушаалууд
2. Цахим систем болон өдөр тутмын сонинд нийтэлсэн тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнгийн мэдээлэл
3. Тендерийн нээлт хийж, цахим системээс татсан мэдээлэл, нээлтийн тэмдэглэл
4. Тендерийн баримт бичиг батлах тухай хурлын тэмдэглэл №01, цахим системээс татсан тендерийн нээлтийн тэмдэглэл, тендерийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан тухай хурлын тэмдэглэл №02,
5. Үнэлгээний хорооны гишүүдийн үнэлгээний хороонд ажиллахыг зөвшөөрсөн мэдэгдэл,
6. Үнэлгээний хорооны гишүүдийн "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"

d/A4
6712020232

7. “Мөрөн буян ундрах” XXK-аас ирүүлсэн тендерийн баримт бичгийг цахимаар хүргүүлэв.

Дээрх баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТХуулийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дэх хэсгүүдэд заасны дагуу архивын нэгж болгон хадгалахыг анхааруулж байна.

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

6716129361 4131053

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn

2022.05.09 № 1/365

танай ____________ -ны № ________________-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Биеийн тамирын гадна талбайн тохижилт /Дэлгэрмөрөн цогцолбор ерөнхий боловсролын сургууль/ ажлын гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212046 дугаартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаар www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад "Хөвсгөл хүрмэн" ХХК 49,565,045 төгрөгийн, "Эндус-Эрхэт" ХХК 49,555,000 төгрөгийн үнийн саналтай тендерүүдийг тус тус ирүүлсэн байна.

Биеийн тамирын гадна талбайн тохижилт /Дэлгэрмөрөн цогцолбор ерөнхий боловсролын сургууль/ ажлын гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212046 дугаартай ажлыг гүйцэтгэхээр "Хөвсгөл хүрмэн" ХХК-ийн ирүүлсэн 49,565,045 (Дөчин есөн сая таван зуун жаран таван мянга дөчин таван) төгрөгийн үнийн саналтай тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх шаардлагыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байна.

Иймд уг төсөлд "Хөвсгөл хүрмэн" ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна.

"Эндус Эрхэт" ХХК-ийн ирүүлсэн тендер нь захиалагчийн тендерийн баримт бичгийн ТШЗ-ын 15.6.4-ийн 3-т заасан *"хүснэгтэд заасан гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн машин механизмуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байх шаардлагатай"* гэх, ТШЗ-ын 15.6.4-т *"Уг ажлыг гүйцэтгэхэд автогрейдер ашиглах шаардлагатай тул тендерт оролцогч нь автогрейдер ашиглах түрээсийн гэрээг 2022 онд хийсэн байгааг ирүүлнэ"* гэсэн шаардлагуудыг тус тус хангаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалтад нийцээгүй тул мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтын дагуу уг тендерээс татгалзаж, шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлнэ үү.

Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь заалтын дагуу чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал эцсийн санхүүжилтээс аймгийн Төрийн сангийн 100-170051305 тоот дансанд авч байршуулах, эсвэл Засгийн газрын бондоор баталгаа гаргуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд барьцаалсан мөнгөн хөрөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгож болно.

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

d/A4
6712020233

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn

2022.05.09 № 1/367

танай ______________ -ны № __________________-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг (Хөвсгөл, Рэнчинлхүмбэ, Хоног цол, VI.1.16)"гүйцэтгэгч сонгох XVIII.1.1 БОАЖЯ/202202052 дугаартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаар www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад "Тод горхи" ХХК 98,753,736 төгрөгийн үнийн саналтай тендерийг ирүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг (Хөвсгөл, Рэнчинлхүмбэ, Хоног цол, VI.1.16)"гүйцэтгэгч сонгох БОАЖЯ/202202052 дугаартай тендерийн оролцсон "Тод горхи" ХХК-ийн ирүүлсэн 98,753,736 (Ерэн найман сая долоон зуун тавин гурван мянга долоон зуун гучин зургаан) төгрөгийн үнийн саналтай тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байна.

Иймд уг тендерт "Тод горхи" ХХК -тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулахыг зөвлөж байна.

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

d/A4
6712020235

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn

2022.05.09 № 1/368

танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн оруулалтаар санхүүжихээр батлагдсан "Автогредер худалдан авах (Улаан-Уул сум) төсөл арга хэмжээг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212052 дугаартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дахин зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад дор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтад "Оттомир" ХХК 134,600,000 төгрөгийн үнийн саналтай тендерийг ирүүлсэн байна.

Автогредер худалдан авах (Улаан-Уул сум) төсөл арга хэмжээг нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202212052 дугаартай барааг нийлүүлэхээр "Оттомир" ХХК - ийн ирүүлсэн тендерийн баримт бичиг нь ТШЗ 17.2.1 Шүүхийн тусгай архивын лавлагаа цахимаар ирүүлнэ гэсэн боловч ирүүлээгүй ТШЗ 18.6.3 инженер, борлуулалтын менежер шаардсан буюу инженер, техникийн ажилтнуудын 50 ба түүнээс доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд У.Амартүвшин, Т.Отгонбаяр нарын ажилтны мэдээлэл ирүүлсэн боловч нийгмийн даатгалын шимтгэлийг 2021 оны 10, 11, 12 дугаар сарuudад тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах гэсэн боловч төлөөгүй тул шаардлага хангахгүй байгаа тул Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дэх заалтыг хангахгүй тул татгалзахаар шийдвэрлэв.

АЛБАНЫ ДАРГА Б.БОЛД

67*5 ... 4131053

d/A4
6712020237

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
Цахим шуудан:khuvsgul-tender@khs.gov.mn
Цахим хуудас: http:/umch.khs.gov.mn
2022 . 05 . 10 № 1/373
танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН АХМАД НАСТНЫ
АСРАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА Т.ОКТЯБРЬБАЯР ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Танай байгууллагын хүсэлтийн дагуу Хөвсгөл аймгийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн хүнсний материал нийлүүлэх ХӨАААҮТ/202212012/ дугаартай тендерийг www.tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг хянаад доор дурдсан зөвлөмжийг хүргүүлж байна.

Хөвсгөл аймгийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн хүнсний материал нийлүүлэх ХӨАААҮТ/202212012/ дугаартай тендерийг нээлтэй тендер шалгаруулалтын аргаар 2 удаа зохион байгуулж багц-1 Мах махан, бүтээгдхүүн нийлүүлэх “Овоонам” ХХК 50,100,000 төгрөгийн, багц-4 Хүнсний ногоо нийлүүлэх “Овоонам” ХХК 10,915,000 төгрөгийн, багц-5 Сүү сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх “Мөрөнбуян ундрах” ХХК 8,750,000 төгрөгийн үнийн саналтай тендерүүд шалгарч гэрээ байгуулагдсан.

Хөвсгөл аймгийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ХӨАААҮТ/202212012/ дугаартай тендерийн багц-2 Дотоодын үйлдвэрийн хүнсний бараа нийлүүлэх 10,574,000 /Арван сая таван зуун далан дөрвөн мянган/ төгрөгийн, багц-3 Талх гурилан бүтээгдхүүн нийлүүлэх 8,665,200 /Найман сая зургаан зуун жаран таван мянга хоёр зуун/ төгрөгийн, багц-6 Гадаадад үйлдвэрлэдэг хүнсний бараа нийлүүлэх 9,095,800 / Есөн сая ерэн таван мянга найман зуун/ төгрөгийн тендерүүдийг нээлтэй тендер шалгаруулалтын аргаар 2 удаа зарлаад нэг ч оролцогчгүй байгаа тул гэрээ шууд байгуулах аргыг сонгож ажиллана уу гэсэн үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй байна.

Иймд уг төсөл арга хэмжээний багц-2 Дотоодын үйлдвэрийн хүнсний бараа нийлүүлэх, багц-3 Талх гурилан бүтээгдхүүн нийлүүлэх, багц-6 Гадаадад үйлдвэрлэдэг хүнсний бараа нийлүүлэх гүйцэтгэгч сонгох ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтын дагуу зохион байгуулахыг зөвлөж байна.

Захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа дараах зүйлийг анхаарна уу.

1. Шалгарсан болон шалгараагүй оролцогчдод хуулийн хугацаанд нэгэн зэрэг мэдэгдэл хүргүүлэх,
2. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах,
3. Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон барааны нэгжийн үнэ өөрчлөгдөхгүй байхаар бараа нийлүүлэлтийн хуваарьт тусгаж, нийт үнээр гэрээ байгуулна.
4. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу www.shilendans.gov.mn сайт болон орон нутгийн цахим сайтад тендер


6712020246

шалгаруулалтын ерөнхий мэдээллийг тендер нээсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор байршуулах,

5. Гэрээ байгуулахад оролцсон төрийн албан хаагчдаас “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бөглөж Авилгатай тэмцэх газрын сайтад шивж оруулах,
6. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, гэрээг дүгнэх,
7. Санхүүжилтийн хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, бараа бүрийн техникийн тодорхойлолтыг захиалагч, гүйцэтгэгчээр баталгаажуулж гэрээнд хавсаргах,
8. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлд: Гэрээний нэр, үнэ, өртөг, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд оруулсны дараа гүйцэтгэгчид санхүүжилт олгох тухай зааж өгөх.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас:7038 8849, 7038 8821, факс: 7038 8848
